



МОНГОЛ УЛСЫН  
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 276

Улаанбаатар хот


Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.6, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1, 5.5 дүгээр зүйлийн 14, 7.1 дэх зүйлийн 1, мөн энэ зүйлийн 3, 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 208 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн 2023 оны 2023/08, 2023/09 дүгээр хурлаас тус тус гаргасан шийдвэрийн дагуу геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгож байгаа 6 /зургаа/ хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр, геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай сунгаж байгаа 4 /дөрөв/ хуулийн этгээдийн жагсаалтыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, сунгасан хуулийн этгээдэд мэдэгдэж, тус этгээдтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (А.Энхманлай)-т даалгасугай.

3. Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой явцын мэдээлэл, шийдвэрийг зөвшөөрлийн нэгдсэн санд бүртгүүлэхийг, мөн энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газар (Э.Батболд)-т үүрэг болгосугай.



Ц.ДАВААСҮРЭН

152310706

Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны  
12 дугаар сарын 06 ны өдрийн 26 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Регистрын дугаар	Олгосон тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлийн дугаар ТЗ/2022/.../	Гэрчилгээний дугаар
1.	"Ти Эйм Эйч сүрвэй" ХХК	3647633	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/078	2023/10/09/078
2.	"Инженермаркшейдер" ХХК	5403561	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/079	2023/10/09/079
3.	"Эко лэнд менежмент" ХХК	6428045	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/080	2023/10/24/080
4.	"Дижитал картографик" ХХК	6881084	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/081	2023/10/24/081
5.	"Арандан топо" ХХК	6755038	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/082	2023/10/24/082
6.	"Геоматик центр" ХХК	6576621	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/083	2023/10/24/083

--- оОо---

Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны  
12 дугаар сарын 26 ны өдрийн 26 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАСАН ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Регистрын дугаар	Сунгасан тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлийн дугаар ГЗ 2022/.../	Гэрчилгээний дугаар
1.	"Профешнл ланд" сүрвэй ХХК	6478948	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/084	2023/10/24/084
2.	"Хувилгаангазар" ХХК	4135091	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/085	2023/10/24/085
3.	"Тэгшхэм групп" ХХК	2791692	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/086	2023/10/24/086
4.	"Бэстсүрвей" ХХК	5243882	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/087	2023/10/24/087

--- оОо---